МЭДЭЭ · 2023 оны 5-р сарын 5

ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТ ДӨРӨВДҮГЭЭР САРД БУУРЧЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ
/2023.04.01-2023.05.01/

Нийт зөрчил 201.652 25.5%

Нийслэлд 149.043

Орон нутагт 52.609

Цагдаа	193.929
Гаалийн байгууллага	192
Татварын байгууллага	180
Гадаадын иргэн, харьяатын газар	193
Онцгой байдлын газар	82
Бусад	6849

Зөрчлийн улмаас учирсан хохирол 1.752.742.000 төгрөг

Төлөгдсөн хохирол 988.253.000 төгрөг

Шийтгүүлсэн хүн 193.967

Хуулийн этгээд 412

149.929

44.043

16-18 нас	435	36-45 нас	56.914
18-25 нас	25.129	46-55 нас	28.866
26-35 нас	68.828	56-аас дээш нас	13.251

Өссөн зөрчил

Татварын хууль зөрчих 88

Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх 88

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих 55

Буурсан зөрчил

Гаалийн тухай хууль 1267

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 628

Хүүхдийн эрхийг зөрчих 321

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 169.771

prokuror.mn

2023 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 201.652 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн. Энэ нь 3 дугаар сартай харьцуулахад 25.5%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан нийт хэргийн 96.1 хувийг Цагдаагийн байгууллага, 0,09 хувийг Гаалийн байгууллага, 0,08 хувийг Татварын байгууллага, 0,09 хувийг Гадаадын иргэн, харьяатын газар, 0,04 хувийг Онцгой байдлын газар, 3,3 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд шалгаж шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд өнгөрөгч 4 дүгээр сард 193.967 хүн, 412 хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон шүүхээс Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл оногдуулсан. Өмнөх сараас шийтгэл оногдуулсан хүн 26.3 хувиар, хуулийн этгээд 3.33 хувиар тус тус буурчээ.

Видео: https://www.youtube.com/watch?v=NU3Q-zFKf4w

Зөрчил үйлдсэн хүмүүсийн 77,2 хувь нь эрэгтэй, 64,7 хувь нь 26-45 насны хүмүүс байна.

Дөрөвдүгээр сард үйлдэгдсэн зөрчлийг гуравдугаар сартай харьцуулахад Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил 17 хувиар, Татварын хууль зөрчих зөрчил болон Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчил тус бүр 18.9 хувиар өссөн байна.

Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 43.2 хувиар, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил 38.2 хувиар, Гаалийн тухай хууль зөрчих зөрчил 19.4 хувиар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 27.9 хувиар тус тус буурчээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1861